



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2018 оны 08 сарын 28 өдөр

Дугаар А/344

Улаанбаатар хот

Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хэвийн
ажиллагааг хангах, засвар үйлчилгээ хийх
журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Засгийн газрын 2017 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого"-ын 2.4.5.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах, засвар үйлчилгээ хийх журам"-ыг нэгдүгээр, "Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах, засвар үйлчилгээ хийх гэрээний үлгэрчилсэн загвар"-ыг хоёрдугаар, "Эмнэлгийн шинэ тоног төхөөрөмж хүлээн авах акт"-ыг гуравдугаар, "Засвар үйлчилгээний дараа хүлээлцэх акт"-ыг дөрөвдүгээр, "Эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалт, аюулгүй ажиллагааны сургалтын мэдээлэл"-ийг тавдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү журмыг мөрдөж ажиллахыг бүх шатны эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

3. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эм, үйлдвэрлэл, технологийн газар /Д.Оюунчимэг/-т даалгасугай.

4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2005 оны 298 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ

081412

Эрүүл мэндийн сайдын
2018 оны 08 сарын 28 өдрийн
А/344 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ХЭВИЙН АЖИЛЛАГААГ ХАНГАХ, ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭ ХИЙХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү журмын зорилго нь эрүүл мэндийн байгууллагад ашиглагдаж байгаа эмнэлгийн тоног төхөөрөмжийн хэвийн, найдвартай үйл ажиллагааг хангах, засвар үйлчилгээ хийх болон түүнтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Эрүүл мэндийн байгууллагын бүтэц үйл ажиллагааны стандартад эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер, техникчийг орон тоогоор ажиллуулахыг шаардаагүй байгууллага, эсхүл өндөр өртөгтэй, нарийн үйл ажиллагаатай эмнэлгийн тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах, засвар үйлчилгээ хийх ажлыг гэрээгээр гүйцэтгүүлж болно.
- 1.3 Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Эмнэлгийн тоног төхөөрөмжийн асуудал хариуцсан нэгж нь эмнэлгийн тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах, засвар үйлчилгээ хийх үйл ажиллагаа болон засвар үйлчилгээний гэрээний гүйцэтгэлд хяналт тавьж ажиллана.

Хоёр. Нэр томъёоны тодорхойлолт

- 2.1 “Эмнэлгийн тоног төхөөрөмж” гэж өвчин, эмгэг, гэмтэл согогийг оношилох, эмчлэх, хянах, сэргээн засахад хэрэглэгдэх, мэргэжлийн үйл ажиллагаа шаардлагатай, бие даасан ажиллагаа бүхий, иж бүрэн бүтээгдэхүүнийг;
- 2.2 “Эмнэлгийн тоног төхөөрөмжийн сэлбэг” гэж эмнэлгийн тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагаанд шаардлагатай эд ангийг;
- 2.3 “Техникийн бичиг баримт” гэж эмнэлгийн хэрэгслийн түүхий эд, бүтэц, үйл ажиллагаа, зарчим, чанар аюулгүй байдал, зориулалт, ашиглах арга аргачлал, заавар, техникийн үзүүлэлт зэргийг агуулсан баримт бичгийг;
- 2.4 “Урьдчилсан үзлэг” гэж тоног төхөөрөмж, түүний дагалдах хэрэгслийн хэвийн ажиллагааг шалгах үзлэг үйлчилгээг;
- 2.5 “Техник үйлчилгээ” гэж тоног төхөөрөмжийг эвдэрч, гэмтэхээс урьдчилан сэргийлэн задалж цэвэрлэх, тослох, шалгах, тохируулах, бэхлэх зэрэг үйл ажиллагааг;
- 2.6 “Урсгал засвар” гэж эмнэлгийн тоног төхөөрөмжийн хугацаат сэлбэг хэрэгсэл, эд ангийг солих хийх үйл ажиллагааг;
- 2.7 “Засвар үйлчилгээ” гэж тоног төхөөрөмж доголдсон, гэмтсэн, эвдэрсэн тохиолдолд хэвийн ажиллагаанд оруулахыг тус тус ойлгоно.

Гурав. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах, засвар үйлчилгээ хийх үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага

- 3.1 Эрүүл мэндийн байгууллагын эмнэлгийн тоног төхөөрөмжийн алба, нэгж нь засвар үйлчилгээ хийж гүйцэтгэхэд дараах шаардлагыг хангасан байна.
 - 3.1.1 Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер, техникч нь хөдөлмөрийн болон цахилгааны аюулгүй байдал, эрүүл ахуй, эмнэлгийн тоног төхөөрөмжид засвар

3.2.5 Захиалагч нь хэвийн ажиллагааг хангах, засвар үйлчилгээ хийх эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэдээллийг гаргаж гүйцэтгэгчид бичгээр болон цахимаар хүргэнэ.

3.2.6 Гэрээнд засвар үйлчилгээ хийхэд шаардлагатай болон хугацаат сэлбэг хэрэгслийн жагсаалт, урьдчилсан үзлэг, техник үйлчилгээ, урсгал засварын хуваарь, зардлын тооцоо, санхүүжилтийн эх үүсвэрийг заавал тусгана.

3.2.7 Гүйцэтгэгч нь эмнэлгийн тоног төхөөрөмжийг хариуцсан эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтэнд ашиглалт, аюулгүй ажиллагааны зааварчилгаа, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч, сургалт зохион байгуулна.

3.2.8 Захиалагч нь гэрээнд тусгагдсанаас бусад ажил гүйцэтгүүлэх тохиолдолд хоёр тал харилцан зөвшилцөж, гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулна.

3.2.9 Гэрээний дагуу хийж гүйцэтгэсэн засвар үйлчилгээ болон сольсон сэлбэг хэрэгсэлд гүйцэтгэгч нь баталгаат хугацаа гаргаж өгнө.

3.2.10 Гэрээний төлбөрийн хэмжээ, төлөх нөхцөлийг харилцан тохиролцож гэрээнд тусгана.

Дөрөв. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах, засвар үйлчилгээ хийх үйл ажиллагаа

4.1 Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг ханган ажиллахад эмнэлгийн тоног төхөөрөмжийн алба, нэгж болон гүйцэтгэгч нь дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.1.1 Эмнэлгийн тоног төхөөрөмжийн урьдчилсан үзлэг, техник үйлчилгээ, урсгал засварын төлөвлөгөөг үйлдвэрлэгчийн техникийн баримт бичгийн болон шалгалт тохируулгын төлөвлөгөөг холбогдох журмын дагуу төлөвлөн хэрэгжилтийг тайлагнаж ажиллана.

4.1.2 Эмнэлгийн тоног төхөөрөмжийн урьдчилсан үзлэгийг инженерийн боловсруулан батлуулсан “Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг шалгах хуудас”-ын дагуу хийж гүйцэтгэнэ.

4.1.3 Эмнэлгийн шинэ тоног төхөөрөмжийг хүлээн авах техникийн комисс нь тушаалын гуравдугаар хавсралтаар батлагдсан “Шинэ тоног төхөөрөмж хүлээн авах акт”-ын дагуу бүртгэн хүлээн авч, мэдээллийг “Эмнэлгийн тоног төхөөрөмжийн төлөвлөлтийн систем” програмд ажлын 5 өдрийн дотор оруулна.

4.1.4 Техникийн комисс нь үйлдвэрлэсэн он, загвар тодорхойгүй, үйлдвэрлэгчийн гарын авлагагүй, экспортлохын өмнө тухайн улсдаа шалгалт тохируулгад хамрагдсан тухай баримт бичиг үгүй /хуучин/ эмнэлгийн тоног төхөөрөмжийг болон импортын тусгай зөвшөөрөлгүй рентген тоног төхөөрөмжийг хүлээн авахаас татгалзана.

4.1.5 Эмнэлгийн тоног төхөөрөмжид урьдчилсан үзлэг, техник үйлчилгээ, урсгал засвар, засвар үйлчилгээ хийх бүрд техник ашиглалтын паспорт болон “Эмнэлгийн тоног төхөөрөмжийн төлөвлөлтийн систем” програмд тэмдэглэл хөтөлнө.

4.1.6 Өндөр өртөгтэй, нарийн үйл ажиллагаатай эмнэлгийн тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах, засвар үйлчилгээ хийхдээ гэрээ байгуулан ажиллах шаардлагатай талаар инженерийн дүгнэлт гаргаж тухайн оны төсөвт тусгах талаар байгууллагын удирдлагад танилцуулна.

4.1.7 Эмнэлгийн тоног төхөөрөмжийн шалгалт тохируулга, шалгалт тохируулгын үр дүнгийн хуудсыг бүртгэж хадгална.

4.1.8 Эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалт, аюулгүй ажиллагааны сургалтын төлөвлөгөө, удирдамжийг боловсруулан батлуулж, тоног төхөөрөмжтэй харьцан ажилладаг эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтэнд зургаан сард нэг удаа сургалт зохион байгуулна.

4.1.9 Шинээр ажилд орсон эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтэнг ажилд томигдсоноос хойш ажлын 5 хоногийн дотор эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалт, аюулгүй ажиллагааны сургалтад хамруулна.

4.1.10 Сургалтын удирдамж, хөтөлбөр, материал, хамрагдсан эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтний мэдээллийг тушаалын тавдугаар хавсралтаар батлагдсан “Эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалт, аюулгүй ажиллагааны сургалтын мэдээлэл”-ийн тэмдэглэл хөтөлж баталгаажуулан хадгална.

4.1.11 Эмнэлгийн тоног төхөөрөмжийн үйлдвэрлэгчийн техникийн баримт бичгийн дагуу ашиглалт, аюулгүй ажиллагааны зааварчилгааг Монгол хэл дээр боловсруулан батлуулж, хэрэглэгчид ойр газар байрлуулна.

4.2 Эмнэлгийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг хийхэд эмнэлгийн тоног төхөөрөмжийн алба болон гүйцэтгэгч нь дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.2.1 Засвар үйлчилгээний дуудлагын дагуу эмнэлгийн тоног төхөөрөмжийн нөхцөл байдалтай танилцан гэмтлийг оношилж, хөнгөн гэмтэлтэй тохиолдолд засвар үйлчилгээг түргэн шуурхай хийж гүйцэтгэн хэвийн ажиллагаанд оруулна.

4.2.2 Эмнэлгийн тоног төхөөрөмжийн эвдрэл, гэмтлийг оношлох, засвар үйлчилгээ хийхэд 1-ээс дээш цаг шаардлагатай бол тухайн тоног төхөөрөмжийг хариуцан ажилладаг эмч, сувилагч эсхүл тасгийн эрхлэгчид мэдээлнэ.

4.2.3 Засвар үйлчилгээг хийж гүйцэтгэхэд 2 болон түүнээс дээш хоног зарцуулах, сэлбэг хэрэгсэл худалдан авах шаардлагатай тохиолдолд инженерийн дүгнэлт, санхүүгийн тооцоог гарган эмнэлгийн удирдлагад танилцуулан цаашид авах арга хэмжээг тодорхойлно.

4.2.4 Эмнэлгийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг хийж гүйцэтгэсний дараа тушаалын дөрөвдүгээр хавсралтаар батлагдсан “Засвар үйлчилгээний дараа эмнэлгийн тоног төхөөрөмжийн хүлээлцэх акт” болон техник ашиглалтын паспортад тэмдэглэл хөтлөн хариуцсан эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтэн, инженер, техникчид хүлээлгэн өгч, гарын үсгээр баталгаажуулна.

Тав. Талуудын эрх, үүрэг

5.1 Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын эмнэлгийн тоног төхөөрөмжийн асуудал хариуцсан нэгжийн эрх, үүрэг

5.1.1 Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг хангах, засвар үйлчилгээ хийх нэгдсэн бодлого, зохицуулалтаар хангаж, хэрэгжилтэд хяналт тавих;

5.1.2 Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг хангах, шалгалт тохируулга, засвар үйлчилгээ хийх болон эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер, техникчдыг орон тоогоор ажиллуулахад шаардлагатай төсөв, санхүүжилтээр хангах;

5.1.3 Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт, төлөвлөлтийн бодлогод оновчтой шийдвэр гаргаж, цөөн үйлдвэрлэгчийн эмнэлгийн тоног төхөөрөмжийг эрүүл мэндийн байгууллагад нийлүүлэх бодлогыг баримтлах;

5.2 Эрүүл мэндийн хөгжлийн төвийн эмнэлгийн тоног төхөөрөмжийн асуудал хариуцсан алба, нэгжийн эрх, үүрэг

5.2.1 Эмнэлгийн тоног төхөөрөмжийн урьдчилсан үзлэг, техник үйлчилгээ, урсгал засвар, шалгалт тохируулга, шалгалт тохируулгын төлөвлөгөөний биелэлт, гэрээт засвар үйлчилгээний гүйцэтгэлд явцын үнэлгээ хийх;

5.2.2 Эрүүл мэндийн байгууллага болон эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер, техникч, эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх;

5.2.3 Шаардлагатай болон гэмтэлтэй эмнэлгийн тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл, дагалдах хэрэгслийн мэдээллийг эрүүл мэндийн байгууллагаас авч, нэгтгэн Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

5.3 Эрүүл мэндийн байгууллагын удирдлагын эрх, үүрэг

5.3.1 Эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалт, засвар үйлчилгээний явц болон урьдчилсан үзлэг, техник үйлчилгээ, урсгал засвар, шалгалт тохируулгын төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавих;

5.3.2 Эрүүл мэндийн байгууллагын бүтэц, үйл ажиллагааны стандартын дагуу эмнэлгийн ачааллыг тооцон эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер, техникчийг орон тоогоор ажиллуулах;

5.3.3 Засвар үйлчилгээ хийх орчин нөхцөлийг хангах;

5.3.4 Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженерийн санал, дүгнэлтийг үндэслэн шаардлагатай эмнэлгийн тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл, дагалдах хэрэгсэл, гэрээт засвар үйлчилгээ, шалгалт тохируулга хийх зардлыг байгууллагын жил бүрийн төсөвт тусган батлуулах, сэлбэг хэрэгсэл, дагалдах хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх, яаралтай засвар үйлчилгээ хийх зардлыг тухай бүр шийдвэрлэх;

5.3.5 Өндөр өртөгтэй, нарийн бүтэц үйл ажиллагаатай эмнэлгийн тоног төхөөрөмжийн үйлдвэрлэгчийн сургалтад эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер, техникчийг заавал хамруулах, чадавхижуулах, мэргэшүүлэх, туршлага судлахад дэмжлэг үзүүлэх;

5.3.6 Эмнэлгийн тоног төхөөрөмж захиалах, нийлүүлэгдэх явцад хяналт тавих, шинэ, дэвшилтэт техник технологи нэвтрүүлэх, нутагшуулах багийн үйл ажиллагаанд эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженерийг оролцуулах;

5.4 Эмнэлгийн тоног төхөөрөмжийн алба болон инженер, техникчийн эрх, үүрэг

5.4.1 Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хэвийн найдвартай үйл ажиллагааг бүрэн хариуцах;

5.4.2 Эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтэнд эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалт, хадгалалт, зөөвөрлөлтийн үйл ажиллагаанд хяналт тавих;

5.4.3 Гэрээт засвар үйлчилгээний гүйцэтгэл, тоног төхөөрөмжийн угсралт суурилуулалтын үйл ажиллагаанд хяналт тавих;

5.4.4 Эмнэлгийн тоног төхөөрөмжийн захиалга, төлөвлөлтийн үйл ажиллагаанд оролцож, тоног төхөөрөмжийг сонгох, техник үзүүлэлт боловсруулахад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх;

5.4.5 Засвар үйлчилгээний талаар дэлгэрэнгүй мэдээллийг эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтэн, тасгийн эрхлэгч болон байгууллагын удирдлагад тухай бүр мэдээлэх;

5.4.6 Эмнэлгийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ хийхэд шаардлагатай сэлбэг хэрэгсэл, дагалдах хэрэгслийг худалдан авах зардлын тооцоог гаргаж, байгууллагын удирдлагаар шийдвэрлүүлэх;

5.4.7 Эмнэлгийн тоног төхөөрөмжийн алба болон инженер нь засвар үйлчилгээ хийхэд шаардлагатай болон хугацаат сэлбэг, дагалдах хэрэгслийн жагсаалтыг гаргаж, байгууллагын удирдлагаар батлуулах;

Зургаа. Тайлагналт, хариуцлага

6.1 Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагаа, засвар үйлчилгээний тайланг маягтын дагуу “Эмнэлгийн тоног төхөөрөмжийн төлөвлөлтийн систем” програмаас гаргаж ирүүлнэ.

6.2 Эрүүл мэндийн байгууллагын эмнэлгийн тоног төхөөрөмжийн алба, инженер гэрээт засвар үйлчилгээний гүйцэтгэлийн тайланг гаргаж Эрүүл мэндийн хөгжлийн төвийн эмнэлгийн тоног төхөөрөмжийн асуудал хариуцсан албанд 5 дугаар сарын 31, 11 дүгээр сарын 30-ны дотор ирүүлнэ.

6.3 Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Эмнэлгийн тоног төхөөрөмжийн асуудал хариуцсан алба нь эрүүл мэндийн байгууллагаас ирүүлсэн засвар үйлчилгээний тайланг нэгтгэж, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад 6 дугаар сарын 15, 12 дугаар сарын 15-ны дотор хүргүүлнэ.

6.4 Эмнэлгийн тоног төхөөрөмжид засвар үйлчилгээ хийх, сэлбэг хэрэгсэл солих төсөв, санхүүжилтийг шийдвэрлээгүйтэй холбоотой гарсан хохирлыг байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтан хүлээнэ.

Эрүүл мэндийн сайдын
2018 оны 08 сарын 28 өдрийн
А/344 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

БАТЛАВ.

БАТЛАВ.

**“ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ХЭВИЙН АЖИЛЛАГААГ ХАНГАХ,
ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭ ХИЙХ” ГЭРЭЭНИЙ ҮЛГЭРЧИЛСЭН ЗАГВАР**

Дугаар №.....

201.. оны ... дугаар сарын ...

Нэг. Ерөнхий зүйл

1.1 Энэхүү гэрээг Монгол Улсын Иргэний хуулийн 343-356 дугаар зүйл болон Эрүүл мэндийн сайдын 201.. оны ... дугаар тушаалаар батлагдсан “Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах, засвар үйлчилгээ хийх журам”-ыг баримтлан нэг талаас (цаашид “Захиалагч” гэх)-ийг төлөөлж ажилтай, нөгөө талаас (цаашид “Гүйцэтгэгч” гэх)-ийг төлөөлж ажилтай нар дараах нөхцөлийг харилцан тохиролцон энэхүү гэрээг байгуулав.

1.2 Гэрээ нь захиалагчийн эмнэлгийн тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах, засвар үйлчилгээ хийхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

Хоёр. Захиалагчийн эрх, үүрэг

2.1 Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг хангах, засвар үйлчилгээ хийх гэрээний хугацаа ... жил эсхүл сарын хугацаатай байна.

2.2 Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах, засвар үйлчилгээ хийж гүйцэтгэхэд шаардлагатай зардлыг бүрэн хариуцаж холбогдох мэдээллээр гүйцэтгэгчийг хангана.

2.3 Гүйцэтгэгчийг засвар үйлчилгээ хийх орчин нөхцөлөөр хангана.

2.4 Эмнэлгийн тоног төхөөрөмжийн үйлдвэрлэгчийн техникийн баримт бичгийн дагуу боловсруулсан ашиглалт, аюулгүй ажиллагааны зааварчилгааг мөрдөж гүйцэтгэгчийн тавьсан шаардлагыг биелүүлнэ.

2.5 Эмнэлгийн тоног төхөөрөмж дээр алдаа заасан эсвэл гэмтэл гарсан тохиолдолд өөрчлөлт хийх, хөдөлгөх, задлах, засвар үйлчилгээ хийх, гүйцэтгэгчийн тавьсан лац тэмдгийг хөндөхийг хориглоно.

2.6 Засвар үйлчилгээ хийх ажлын явц, гэрээний гүйцэтгэлд хяналт тавина.

Гурав. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг

3.1 Шаардлагатай болон хугацаат сэлбэг хэрэгслийн жагсаалт, зардлын тооцоо, урьдчилсан үзлэг, техник үйлчилгээ, урсгал засварын хуваарийг гаргана.

3.2 Талуудын тохиролцсон хугацаанд эмнэлгийн тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах, засвар үйлчилгээг хийхдээ чанарын өндөр түвшинд доголдолгүй хийж гүйцэтгэнэ.

3.3 Засвар үйлчилгээний ажлын тайланг гэрээнд заасан хугацаанд захиалагчид хүргэнэ.

3.4 Засвар үйлчилгээг хийж дууссаны дараа лац тэмдэг тавьж засвар үйлчилгээ болон сольсон сэлбэг хэрэгсэлд баталгаат хугацаа өгнө.

3.5 Эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтэнд эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалт, хадгалалт, зөөвөрлөлтийн үйл ажиллагаанд шаардлага тавина.

3.6 Эмнэлгийн тоног төхөөрөмжийг хариуцсан эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтэнд ашиглалт, аюулгүй ажиллагааны зааварчилгаа, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч, шаардлагатай тохиолдолд сургалт зохион байгуулна.

Дөрөв. Төлбөр тооцоо

4.1 Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах, засвар үйлчилгээг хийх ажлын хөлсийг гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний бодит үр дүнд дүйцүүлэн тооцно. Талууд харилцан тохиролцсоны дагуу урьдчилгаа төлбөр олгож болно.

4.2 Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах, засвар үйлчилгээг хийх ажлын хөлс төгрөг байна.

4.3 Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах, засвар үйлчилгээг хийх ажлын хөлс болох төгрөгийг гүйцэтгэгч засвар үйлчилгээний дараа хүлээлцэх акт, ажлын тайлан хүргүүлснээс хоногийн дотор гүйцэтгэгчийн банкны тоот дансанд шилжүүлнэ.

Тав. Бусад зүйл

5.1 Энэхүү гэрээнд талууд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болох бөгөөд 20.... ныдугаарсарынны өдөр дуусгавар болно.

5.2 Гүйцэтгэх ажлыг гэрээний хавсралтаар батална.

5.3 Гэрээний хугацаа дуусгавар болсны талууд гэрээний хэрэгжилтийг хамтран дүгнэнэ.

5.4 Гэрээг хоёр хувь үйлдэн нэг хувийг гүйцэтгэгч, үлдэх хувийг захиалагч хүлээн авна.

5.5 Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр хугацаанаас өмнө гэрээг дуусгавар болгож болно.

5.6 Ажил гүйцэтгэх хавсралт нь гэрээний салшгүй хэсэг бөгөөд захиалагчийн хүсэлтээр гүйцэтгэх ажилд нэмэлт, өөрчлөлт оруулсан орсон тохиолдолд ажил үйлчилгээний төлбөрийн асуудлыг нэмэлт гэрээгээр тухай бүрд зохицуулж шийдвэрлэнэ.

5.7 Энэхүү гэрээг хэрэгжүүлэхтэй холбогдон үүссэн маргааныг талууд зөвшилцөн шийдвэрлэнэ. Эс зөвшилцвөл асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

Гүйцэтгэгч байгууллагыг төлөөлж:

.....
.....

Захиалагч байгууллагыг төлөөлж:

.....
.....

Эрүүл мэндийн сайдын
2018 оны 08 сарын 28 өдрийн
А/Б.44 дугаар тушаалын 3 дугаар хавсралт

ЭМНЭЛГИЙН ШИНЭ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ ХҮЛЭЭН АВАХ АКТ

1. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэдээлэл

1.1 Тоног төхөөрөмжийн нэр

1.2 Марк модель

1.3 Үйлдвэрлэсэн улс

1.4 Үйлдвэрлэгч байгууллага

1.3. Үйлдвэрийн дугаар

1.4. Үйлдвэрлэсэн он сар

2. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн техник үзүүлэлт

2.1

2.2

2.3

2.4

2.5

2.6

3. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн иж бүрдлийн жагсаалт

3.1

3.2

3.3

3.4

4. Хүлээлцсэн байдал

4.1 Эх үүсвэр

4.2 Нийлүүлсэн байгууллагын нэр

4.3 Ажиллагааг шалгасан байдал

4.4 Сургалт зохион байгуулсан байдал

4.5 Суурилагдсан тасаг

4.6 Ашиглалтад орсон он сар

**5. Хүлээлцэх явцад гарсан зөрчил,
дутагдал.**

6. Авсан арга

хэмжээ.

Хүлээлгэж өгсөн комисс:

1. /...../

2. /...../

Хүлээн авсан комисс:

1. /...../

2. /...../

3. /...../

ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ДАРАА ХҮЛЭЭЛЦЭХ АКТ

1. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэдээлэл

- 1.1 Тоног төхөөрөмжийн нэр
- 1.2 Марк модель
- 1.3 Үйлдвэрийн дугаар

2. Засвар үйлчилгээний мэдээлэл

- 2.1 Дуудлага өгсөн огноо
- 2.2 Засварын тэмдэглэл

2.3 Сольсон сэлбэг хэрэгслийн мэдээлэл

№	Сэлбэг хэрэгслийн нэр	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1				
2				
3				
4				
	Нийт			

- 2.4 Ажиллагааг шалгасан тэмдэглэл

Хүлээлгэж өгсөн ажилтан:

1.
2.

Хүлээн авсан ажилтан:

1.
2.

201... оны ... дугаар сарын ... -ны өдөр

Эрүүл мэндийн сайдын
2018 оны 08 сарын 28 өдрийн
А/344 дугаар тушаалын 5 дугаар хавсралт

**ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН АШИГЛАЛТ, АЮУЛГҮЙ,
АЖИЛЛАГААНЫ СУРГАЛТЫН МЭДЭЭЛЭЛ**

1. Сэдэв:
2. Хугацаа:
3. Хамрагдах тасаг нэгж:
4. Оролцогчдын тоо:
5. Сургалтын зорилго:
.....
.....
6. Сургалтын зорилт:
.....
.....
7. Сургалтаар эзэмшвэл зохих чадвар, дадал, мэдлэг:
.....
.....
8. Оролцогчдын бүртгэл /дэлгэрэнгүй мэдээллийг хавсаргах/:
9. Сургагч багшийн нэр:
 1. /...../
 2. /...../

201... оны ... дугаар сарын ... –ны өдөр